

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сонгинохайрхан дүүргийн Буянт манал ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/237/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

НТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал
Утас: Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn
Ахлах менежер: Х.Түвшинбаяр
Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
менежер: С.Гантөгс
Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn
Аккаунт траст аудит ХХК-ийн захирал: П.Наранцэцэг
Цахим хаяг: acctrust.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

0226-05-13

№

798

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН
ДҮҮРГИЙН БУЯНТ МАНАЛ
ӨЭМТ-ИЙН ДАРГА Э.ХУЛАН
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Буянт манал ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Сонгинохайрхан дүүргийн Буянт манал ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 80.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2, 29 дүгээр зүйлийн 29.2, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, 27 дугаар зүйлийн 27.1, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр эрүүл мэндийн даатгалын сангаас 1,088.0 сая төгрөгийн санхүүжилт авч ажилласан байна.

1426050835

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Нийслэлийн засаг даргын 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/47 дугаар захирамжаар Сонгинохайрхан дүүргийн Буянт манал ӨЭМТ-ийн 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг 96.4 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

Сонгинохайрхан дүүргийн Буянт манал ӨЭМТ-ийн 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Хоёр.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	134,138.79	84,543.96
1.1.4	Бусад авлага	65,975,322.78	14,889,626.10
1.1.6	Бараа материал	109,439,758.53	100,691,616.53
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	175,549,220.10	115,665,786.59
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	204,102,904.90	164,138,576.96
1.2.2	Биет бус хөрөнгө	1,292,500.00	962,500.00
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	205,395,404.90	165,101,076.96
1.3	НИЙТ ХӨРӨНГӨ	380,944,625.00	280,766,863.55
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	19,944,416.60	9,487,250.00
2.1.1.2	Цалингийн өглөг		45,998.00
2.1.1.3	Татварын өр	32,036,142.92	68,684,589.86
2.1.1.4	НДШ-ийн өглөг	27,166,377.10	2,264,059.00
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	79,146,936.62	80,481,896.86
2.2	Өр төлбөрийн нийт дүн	79,146,936.62	80,481,896.86
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	90,704,504.80	90,704,504.80
2.3.2	Хувийн өмч	340,000.00	340,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	210,753,183.58	109,240,461.89
2.3.20	Эздийн өмчийн дүн	301,797,688.38	200,284,966.69
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	380,944,625.00	280,766,863.55

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,041,643,170.69	1,088,008,123.80
3	Борлуулалтын өртөг	-	-
4	Нийт ашиг (алдагдал)	1,041,643,170.69	1,088,008,123.80
6	Хүүгийн орлого	315,009.90	311,344.47
7	Үнэ төлбөргүй авсан	-	6,037,541.79
8	Эрхийн шимтгэлийн орлого	246,000.00	-
9	Бусад орлого	93,769,786.53	15,300,000.00
10	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
11	Ерөнхий ба удирдлагын зардал	1,104,490,829.70	1,216,341,581.93
19	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	31,483,137.42	(106,684,571.87)
20	Орлогын татварын зардал	-	-
21	Татварын дараах ашиг (алдагдал)	31,483,137.42	(106,684,571.87)
22	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
23	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	31,483,137.42	(106,684,571.87)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	91,004,504.80	2,505,993.59	176,764,052.57	270,274,550.96
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	91,004,504.80	2,505,993.59	176,764,052.57	270,274,550.96
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	31,483,137.42	31,483,137.42
5	Бусад дэлгэрэнгүй орлого	(60,000.00)	-	-	(60,000.00)
6	Өмчид гарсан өөрчлөлт	100,000.00	(2,505,993.59)	2,505,993.59	100,000.00
9	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	91,044,504.80	-	210,753,183.58	301,797,688.38
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	5,171,850.18	5,171,850.18
11	Залруулсан үлдэгдэл	91,044,504.80	-	215,925,033.76	306,969,538.56
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(106,684,571.87)	(106,684,571.87)
	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	91,044,504.80	-	109,240,461.89	200,284,966.69

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,011,452,027.81	1,088,729,842.17
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	866,910,697.91	1,073,118,497.70
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	315,009.90	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	144,226,320.00	15,611,344.47
1.20	Мөнгөн зарлагын дүн (-)	1,004,996,836.80	1,077,659,437.00
1.2.1	Ажиллагчдад төлсөн	648,725,805.19	609,558,470.39
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	153,263,086.02	84,497,457.67
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	72,645,578.10	87,650,201.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	14,635,372.18	12,674,409.60
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	9,610,000.00	6,000,000.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	26,770.63	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	267,300.00	31,818,900.79
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	37,184,896.29	118,800.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	68,638,028.39	245,341,197.55
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,455,191.01	11,070,405.17
2.00	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,023,900.00	11,120,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	7,023,900.00	11,120,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(7,023,900.00)	(11,120,000.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	29,000,000.00	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	28,900,000.00	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	100,000.00	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	28,860,000.00	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	28,800,000.00	
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж төлсөн	60,000.00	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	140,000.00	-
5.00	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(428,708.99)	(49,594.83)
6.00	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	562,847.78	134,138.79
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	134,138.79	84,543.96

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 135,510.3 мянган¹ алдаа^[06] илэрснийг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нийт 80,350.4 мянган төгрөгийн зерчил² илэрсэнд 2 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/, НТАГ-2026/237/НА-СТА-ОНӨҮГ

Сонгинохайрхан дүүргийн Буянт манал ӨЭМТ-ийн 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

4.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орлогын дэлгэрэнгүй тайланг 124,273.3 төгрөгийн алдаатай тайлагнасан	1	124,273.3	-	-	1	124,273.3	1	124,273.3	-	-	-	-
2	Өмчийн өөрчлөлтийн тайлангийн эзэмшигчдийн өмчийн дүнг 11,237.0 мянган төгрөг илүү тайлагнасан	1	11,237.0	-	-	1	11,237.0	1	11,237.0	-	-	-	-
	Дүн	2	135,510.3	-	-	2	135,510.3	2	135,510.3	-	-	-	-

Сонгинохайрхан дүүргийн Буянт манал ӨЭМТ-ийн 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

4.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Татварын цахим системд тайлант онд худалдан авсан 9,401.8 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний и баримт бүртгэгдээгүй байна.	1	9,401.8	-	-	-	-	1	9,401.8	-	-	-	-
5	Тайлант онд өр төлбөр 1,335.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 70,948.6 мянган төгрөг болж хуримтлагдсан байна.	1	70,948.6	-	-	-	-	1	70,948.6	-	-	-	-
	Дүн	2	80,350.4	-	-	-	-	2	80,350.4	-	-	-	-